



**ХЭНТИЙ АЙМАГ
ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗРЫН
ДАРГЫН ТУШААЛ**

2017 оны 6 сарын 9 өдөр

Дугаар Б/35

Чингис хот

Х.Болоргэрэлийг ажилд томилох тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 33 дугаар зүйлийн 33.5, 33.4, Төрийн албаны тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.4 дэх заалт, Засгийн газрын 2007 оны "Төрийн захиргааны болон төрийн үйлчилгээний албан тушаалын ангилал, зэрэглэлийг шинэчлэн тогтоох тухай" 354 дүгээр тогтоолын 1 дүгээр хавсралт, 2014 оны "Зарим албан тушаалын цалингийн жишгийг шинэчлэн тогтоох тухай" 332 дугаар тогтоолын 1 дүгээр хавсралтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Туршилтын хугацаанд хүлээсэн үүргээ хангалттай сайн биелүүлж, цаашид төрийн жинхэнэ албанд үр бүтээлтэй ажиллаж чадахаа нотлон харуулсан Хатанбаатарын Болоргэрэлийг Нийгмийн бодлогын хэлтсийн Хүн ам зүйн нийгмийн хамгаалал, хөдөлмөр эрхлэлтийн бодлого хариуцсан мэргэжилтнээр 2017 оны 6 дугаар сарын 09-ний өдрөөс эхлэн томилсугай.

2. Х.Болоргэрэлийн цалинг ТЗ-5-1 шатлалаар тогтоон үндсэн цалин 509948 /таван зуун есөн мянга есөн зуун дөчин найман/ төгрөгөөр, төрийн алба хаасан хугацааны нэмэгдлийг 5 хувиар, зэрэг дэвийн нэмэгдлийг 15 хувиар тооцож олгохыг нягтлан бодогч /Н.Шинэбаяр/-д зөвшөөрсүгэй.

3. Аймгийн Засаг даргын Тамгын газрын Нийгмийн бодлогын хэлтсийн Хүн ам зүйн нийгмийн хамгаалал, хөдөлмөр эрхлэлтийн бодлого хариуцсан мэргэжилтний ажлын байрны тодорхойлолтод заагдсан чиг үүрэг болон хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Х.Болоргэрэлд үүрэг болгосугай.

ДАРГА



Ж.ГАНБААТАР